

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2023 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

АУДИТЫН КОД: БУА-2024/18-04-ШТА-ГА

**БУЛГАН АЙМАГ
2024**

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ
Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 7034-2716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: П.Содном
Утас: 7034-2495 Цахим хаяг: Sodnomp@audit.gov.mn
Аудитор: З.Ганбаатар
Утас: 7034-2716 Цахим хаяг: Ganbaatarz@audit.gov.mn
Аудитор: Д.Даариймаа
Утас 70342716 Цахим хаяг: Daariimaado@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. bulgan@audit.gov.mn

АГУУЛГА	
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2-3
АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙ	4
АУДИТЫН ТАЙЛАН.....	5-17
А.1 АЙМГИЙН ДУНД БОЛОН БОГИНО ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ УЯЛДААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ БАТАЛДАГ ЗӨРЧИЛ ДАВТАГДСАН БАЙНА.	
А.1.1 Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй зарим төсөл, арга хэмжээнүүд батлагдсан байна.	
А.1.2. ОНХО-аар зураг төсөв, ТЭЗҮ хийгдээгүй 700.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.	
Б.1 ЗАХИАЛАГЧ ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХУГАЦААНД НЬ БҮРЭН ХАНГУУЛСАН Ч ЗАРИМ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ЧАНАР ХАНГАЛТГҮЙ БАЙНА.	
Б.1.1 Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.	
Б.1.2 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг үзэхэд зураг төсвийн дагуу хийгээгүй, төсөвт тусгасан ажлуудаас дутуу хийсэн, засварын ажлууд чанаргүй болсон зэрэг зөрчлүүд байна.	
Б.1.3 Хөрөнгө оруулалтаар бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаж байна.	
Б.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ДОТООД БОЛОН ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	
Б.2.1 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна.	
Б.2.2 Хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээнээс 952.6 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагууд бүртгэлд тусгаагүй, 1286.9 сая төгрөгийн их засварын ажлыг капиталжуулаагүй байна.	
АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	16
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ.....	16
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	17-18
ТӨЛБӨРИЙН АКТ.....	19
АЛБАН ШААРДЛАГА.....	20-26

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГУУДЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ҮАГ	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ГАГ	ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ГАЗАР
ГА	ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ
ИТХ	ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ
ЗДТГ	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ГХБХБГ	ГАЗРЫН ХАРИЛЦАА БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
ОНӨГ	ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР
ОНӨХХК	ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХУВЬЦААТ КОМПАНИ
ХХК	ХЯЗГААРЛАГДМАЛ ХУВЬЦААТ КОМПАНИ
ТАХ	ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ
ОНХО	ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
ТЭЗҮ	ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ
ХАА	ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА
ТБОНӨХБАҮХАТХ	ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬ

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
1	Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй төсөл, арга хэмжээ.	5
2	Зураг төсөв, ТЭЗҮ хийгдээгүй төсөл, арга хэмжээ	6
3	Гомдол гарсан худалдан авах ажиллагаа	7
4	Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл хөтөлсөн эсэх.	11
5	Захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй төсөл, арга хэмжээ.	11
6	Данс бүртгэлд тусгаагүй хөрөнгийг хүснэгтээр харуулбал	15
7	Их засварын ажлаас данс бүртгэлд тусгаагүй хөрөнгийг хүснэгтээр харуулбал	16

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоолын дагуу хийлээ.
Аудитын зорилт	Улс, орон нутгийн төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулж дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох тооцоолол, баримт бичгийг үндэслэлтэй боловсруулж, санхүүжүүлсэн үү; - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж, хүлээн авсан уу; - Хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 оноос эхэлсэн төсөл арга хэмжээнд 2023 онд санхүүжилт олгосон 6 төсөл, арга хэмжээг санхүүжүүлсэн, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв болон бусад байгууллага болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-400, АДБОУС-3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, арга зүйг ашиглан ЯАГ-аас ирүүлсэн асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судалгаа, дүн шинжилгээ хийж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ хянан удирдаж, аудитын аудитын менежер Ж.Энхцоодол үе шатны чанарын хяналтыг хийж, ахлах аудитор П.Содном, аудитор З.Ганбаатар, Д.Даариймаа нар хийж гүйцэтгэлээ. Аудитын удирдамжийн дагуу гүйцэтгэлийн аудитыг 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр хүртэл ажлын 15 хоногт хийж аудитыг үе шатны хяналтаар хянуулж аудитын тайланг хавсралт судалгааны хамт 2024 оны 06 дүгээр сарын 19-ний өдөр ЯАГ-т, аймгийн ЗДТГ болон ГХБХБГ-т тус тус хүргүүлж ажилласан.
Хүндрэл бэрхшээл	Аудиттай холбоотой хүндрэл бэрхшээл байхгүй.

А.1 АЙМГИЙН ДУНД БОЛОН БОГИНО ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГОТОЙ УЯЛДААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ БАТАЛДАГ ЗӨРЧИЛ ДАВТАГДСАН БАЙНА.

А.1.1 Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл, арга хэмжээнүүд батлагдсан байна.

Аймгийн ИТХ-аар 2022 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн XII/21 тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад барилга байгууламж, тоног төхөөрөмжийн 16 төсөл арга хэмжээнд 2,949.8, их засварын 14 ажилд 2,401.6 сая төгрөг нийт 5,351.4 төсөвт өртөгтэй 30 төсөл, арга хэмжээ баталжээ.

Аймгийн ИТХ-аар 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар төсөвт өөрчлөлт оруулах тухай IX/16 тогтоолоор барилга байгууламж, тоног төхөөрөмжийн 47 төсөл арга хэмжээнд 6,185.8 сая төгрөг, их засварын 25 төсөл, арга хэмжээнд 3,874.5 сая төгрөг нийт 10,060.3 сая төгрөгийн 72 ажил болгон 42 төсөл арга хэмжээний 4,708.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны шинэ хөгжлийн зам, Булган аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигтэй нийцүүлэн батлахаар заасан байдаг.

Аймгийн 2023 оны хөрөнгө оруулалт, их засварын 72 ажлаас Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй 580.0 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй нийцээгүй 3,183.7 сая төгрөгийн 32 (хавсралт 1) төсөл, арга хэмжээг баталсан байна.

Хүснэгт № 1 Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй төсөл, арга хэмжээ.

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	2023 онд санхүүжүүлэх дүн /сая.төг/
1	Холбооны замын уулзварын гэрлэн дохио (Булган сум)	2023	80.0
2	Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн техник хэрэгсэл	2023	142.0
3	Тусгай тоноглолтой автомашин (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар)	2023	150.0
4	Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл худалдан авах (“Булган Мээж” ОНӨХХК)	2023	85.0
5	Татварын хэлтсийн тавилга, тоног төхөөрөмж	2023	15.0
6	Төсвийн байгууллагуудын сантехникийн засвар (Баяннуур сум)	2023	80.0
7	Дотуур байрны засварын үлдэгдэл санхүүжилт (Бүрэгхангай сум)	2023	28.0
	ДҮН		580.0

Аймгийн хөгжлийн бодлого, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулаагүй төсөл арга хэмжээ нь төсвийн тодотгол хийхэд нэмэгдсэн ажлууд байна. Төсөвт өөрчлөлт оруулах, тодотгол хийхэд төлөвлөлтийн шаардлага хангахгүй ажлуудыг баталж байгаа анхаарч ажиллах шаардлагатай байна.

А.1.2 ОНХО-аар зураг төсөв, ТЭЗҮ хийгдээгүй 700.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэхээр 10,060.3 сая төгрөгийн 72 төсөл, арга хэмжээг баталснаас зураг төсөв хийгдээгүй 700.0 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээг төлөвлөн баталсан байна.

Хүснэгт № 2 Зураг төсөв, ТЭЗҮ хийгдээгүй төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	2023 онд санхүүжүүлэх дүн /сая.төг/
1	Ханжаргалант худалдааны төвөөс Хаан банк хүртэл явган зам шинээр барих (Булган сум)	2023	2024	150.0	75.0
2	Музейн барилгын засвар	2023	2023	120.0	120.0
3	Төсвийн байгууллагуудын сантехникийн засвар (Баяннуур сум)	2023	2023	80.0	80.0
4	Соёлын төвийн барилгын засвар (Сайхан сум)	2023	2023	100.0	100.0
5	Ахмадын амралтын барилгын засвар (Булган сум)	2023	2023	250.0	250.0
Дүн				700.0	625.0

Өмнөх онд нийт төсөл, арга хэмжээний 54.5 хувь буюу 16 төсөл, арга хэмжээг ТЭЗҮ, үр ашгийн тооцоогүй төлөвлөн баталж байсан бол тайлант онд 700.0 сая төгрөгийн 5 ажил баталсан, буурсан хэдий ч зураг төсвийг урьдчилан боловсруулж, магадлалын дүгнэлт гаргуулсны дараа төсөвт тусгах, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.41¹ дэх заалттай нийцүүлэн төлөвлөх, шаардлагатай байна.

Б.1 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулсан ч зарим ажлын гүйцэтгэл, чанар хангалтгүй байна.

Б.1.1 Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд 11,450.4 сая төгрөгийн 72 төсөл, арга хэмжээ төлөвлөснөөс шилжих болон орон нутгийн оролцоо болон үлдэгдэл санхүүжилттэй холбоотой 11 төсөл арга хэмжээнд 1104.7 сая төгрөг

¹

баталж, тайлант онд 9945.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 61 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Үүнээс нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 8055.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27, харьцуулалтын аргаар 1767.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24, шууд гэрээгээр 122.5 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж сонгон шалгаруулсан байна.

Худалдан авах ажиллагааны үнэлгээ, шалгаруулалттай холбоотой 1,917.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ажилд гомдол гаргаж шийдвэрлэсэн байна.

Хүснэгт № 3. Худалдан авах ажиллагаанд гомдол гарсан төсөл, арга хэмжээнүүд

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2023 онд санхүүжүүлэх дүн /сая.төг/	ХАА-нд мөрдөгдсөн журам	Тендерт гомдол гарсан
1	Сумын төвийн гэрэлтүүлэг (Бугат сум)	100.00	100.00	Харьцуулалтын арга	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй.
2	Явган болон дугуйн зам шинээр барих (Булган сум 2490 м)	520.95	520.95	Нээлттэй тендер шалгаруулалт	Гомдол хянагдаад дахин үнэлгээ хийх талаар дүгнэлт ирүүлсэн. Дахин зарласан.
3	Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн техник хэрэгсэл	142.00	142.00	Нээлттэй тендер шалгаруулалт	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй.
4	Биеийн тамир спортын газрын "Б" заалны засвар	250.00	250.00	Нээлттэй тендер шалгаруулалт	Гомдол хянагдаад дахин үнэлгээ хийх талаар дүгнэлт ирүүлсэн. Дахин зарласан.
5	Сургуулийн барилгын засвар (Бүрэгхангай сум)	555.00	555.00	Нээлттэй тендер шалгаруулалт	Захиалагчийн шийдвэр үндэслэлтэй.
6	Сургуулийн барилгын засвар (Хишиг-Өндөр сум)	100.00	100.00	Харьцуулалтын арга	Гомдол хянагдаад дахин үнэлгээ хийх талаар дүгнэлт ирүүлсэн. Дахин зарласан.
	ДҮН	1,667.95	1,662.95		

Дээрх гомдол гарсан 6 төсөл, арга хэмжээний 3 нь захиалагчийн гаргасан шийдвэр зөв, 3 нь дахин үнэлгээ хийх шийдвэр гарч худалдан авах ажиллагааг дахин зарласан байна.

Б.1.2 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг үзэхэд зураг төсвийн дагуу хийгээгүй, төсөвт тусгасан ажлуудаас дутуу хийсэн, засварын ажлууд чанаргүй болсон зэрэг зөрчлүүд байна.



Булган аймгийн ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн XVII/01 дугаар төсөвт өөрчлөлт оруулах тухай тогтоолоор шилжих 6, шинээр хэрэгжих

66 төсөл арга хэмжээ нийт 11,450.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 72 төсөл, арга хэмжээг 2023 онд 10,060.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Баталсан төсөл, арга хэмжээнээс 9,000.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8,595.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 62 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 2,060.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1,075.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл, арга хэмжээ хэрэгжилт дутуу, 390.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 390.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 4 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Үүнээс бүрэн дуусаагүй 6 төсөл, арга хэмжээ дараах нөхцөл, шалтгаанаас хэрэгжилт хангагдаагүй байна.

- Могод сумын биеийн тамирын заалны 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2023 онд 250.0 сая төгрөг олгохоор баталсантай холбоотой,
- Тендер сонгон шалгаруулалтаар шалгарсан "Тааффейд" ХХК барилга угсралтын ажилд 54.8 хувийн санхүүжилтийг олгосон хүлээн авах комисс ажилласан боловч технологийн алдаа гарсан тул ашиглалтад хүлээн аваагүй,
- Аймгийн ЗДТГ-ын лифт суурилуулах ажлыг захиалагчийн талаас лифтийн хонгилын хучилтыг хийх ажил хийгдээгүйд хойшилсон,
- Биеийн тамир спортын газрын "Б" заалны засварын ажлын худалдан авах ажиллагааг оройтож шалгарсан,
- Булган сумын 18 дугаар байр хүртэлх дулааны шугамын шинэчлэлийн ажилд технологийн өөрчлөлт гарсан.
- Булган сумын Ханжаргалант худалдааны төвөөс Хаан банк хүртэл явган зам шинээр барих 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2023 онд 75.0 сая төгрөг олгохоор баталсантай холбоотой байна.

Тайлант онд бүрэн хэрэгжсэн 62 төсөл, арга хэмжээнээс ашиглалт, чанар байдлын талаар санал, гомдол гаргаагүй ч аудитын явцад Сайхан, Хутаг-Өндөр, Бугат, Хангал, Сэлэнгэ сум, Хялганат тосгонд хийсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг үзэхэд зураг төсвийн дагуу хийгээгүй, төсөвт тусгасан ажлуудаас дутуу хийсэн, засварын ажлууд чанаргүй болсон зэрэг зөрчлүүд илэрлээ.

Тухайлбал:

Зураг төсөвт тусгасан ажлуудад өөрчлөлт оруулж хийсэн ажлууд

- **Сайхан сумын соёлын төвийн их засварын ажлыг** “Алист констракшн” ХХК 99.9 сая төгрөгөөр сумын Засаг даргатай гэрээ байгуулж хийсэн ч засварын төсөвт тусгагдсан хяналтын камер хийх 4.3 сая төгрөгийн ажлын төсвөөр цахилгааны гол шугам солих, разетка, унтраалга, автоматын хайрцаг иж бүрнээр сольсон гэх боловч төсөвт өртгийг тооцоогүй.
- **Хутаг-Өндөр сумын соёлын төвийн их засварын ажлыг** “Хурмастын хүлэг” ХХК 214.6 сая төгрөгөөр гэрээ байгуулж хийсэн засварын ажлаас тайзны шалны 1.8 сая төгрөгийн ажлыг хийгдээгүй байна. Энэхүү ажлыг өмнөх жил сумын төсвөөр хийлгэсэн байсан гэх шалтгаанаар ашиглагчийн хүсэлтээр төсөвт тусгагдсан 2 ширхэг төмөр хаалга буюу 1.6 сая төгрөгийн ажлыг 5.0 сая төгрөгийн хаалга суулгасан гэх тайлбарыг захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ГХБХБГ-аас ирүүлсэн.

- **Сэлэнгэ сумын Соёлын төвийн барилгын засварын ажлыг** “Хурмастын хүлэг” ХХК 350.0 сая төгрөгийн гэрээ байгуулж засварын ажлыг хийсэн, үүнээс дотор заслын ажилд 340 м.кв тааз, 165 ш нүдэн гэрэл суулгах ажил хийгдэхээр байсан, энэ ажил нь зураг төсвийн дагуу хийгдээгүй, өөрчлөн өөр ажил хийсэн ч төсвийн тооцоо, зураг төсөвт өөрчлөлт оруулаагүй байна.
- **Сэлэнгэ сумын сургуулийн хичээлийн байрны барилгын их засвар:** Гүйцэтгэгч “Хөх сэрхийн мандал” ХХК 496.0 сая төгрөгөөр гэрээ байгуулсан, засвар хийсэн гал тогооны өрөөний хана, таазны будаг хуурсан, дээврийн карниз, усны хаялаг шинээр хийгээгүй, салхивчийн систем ажиллаагүй байна.
- **Хангал сумын сургуулийн хичээлийн байрны их засварын ажлыг** “Эрдэнэс эко үүр” ХХК 192.4 сая төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгэсэн. Улсын комиссын хурлын тэмдэглэлд цонхны амлагааг гүйцээж хийх үүрэг даалгавар өгсөн ч биелүүлээгүй, захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй байна.

Б.1.3 Хөрөнгө оруулалтаар бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаж байна.

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар шилжих 6, шинээр хэрэгжих 66 төсөл арга хэмжээ нийт 11,450.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 72 төсөл, арга хэмжээг 2023 онд 10,060.4 сая төгрөгөөр санхүүжүүлсэн үүнээс 1,942.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 29 техник, тоног төхөөрөмж, шинээр 2 барилга байгууламж ашиглалтад орсон байна.

2023 онд хөрөнгө оруулалтаар бий болсон зарим хөрөнгийн ашиглалтыг авч үзвэл 491.7 сая төгрөгийн тусгай болон албан хэрэгцээний 6 автомашин, холбогдох байгууллагууд нь бүртгэлд тусган ашиглаж байна.

Булган суманд нийтийн биеийн тамирын талбай, тоглоомын талбай, явган болон дугуйн зам шинээр барих нийт 3 төсөл, арга хэмжээний 1,076.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зам талбайг холбогдох байгууллагууд нь бүртгэлд тусган нийтийн эзэмшлээр хэвийн ашиглаж байна.



Мөн төрийн албан хаагчийн орон сууцыг Хутаг-Өндөр суманд 2 албан хаагч гэр бүлийн хамт, Хангал сумын Хялганат тосгонд 6 айлын орон сууцанд сумын цагдаа, эмч, багш зэрэг 5 төрийн албан хаагч гэр бүлийн хамт амьдарч байгаа нь албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэн ажилласан байна.

Хутаг-Өндөр сум



Хангал сумын Хялганат тосгон



Шинээр хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь гэрээний дагуу хэрэгжсэн барилга байгууламж, их засвар, тоног, төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглаж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

Харин зарим сумдын багийн Засаг дарга нарт 8 ширхэг мотоциклыг 26.7 сая төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг бүрэн нийлүүлсэн ч 3 ширхэг мотоцикл нь дутагдсан байна.

Б.2 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хийсэн дотоод болон хөндлөнгийн хяналтын сайжруулах шаардлагатай байна.

Б.2.1 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт хангалтгүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс захиалагчийн хяналт хийх 30 ажил байна.

Дэд бүтцийн хөгжлийн сайдын 2000 оны 09 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Барилга угсралтын ажил гүйцэтгэсэн тэмдэглэл хөтлөх журмын 2-д “Монгол орны нутаг дэвсгэр дээр баригдаж байгаа бүх төрлийн барилга байгууламж, өргөтгөл, шинэчлэлтийн ажил бүрд ажил эхэлсэн өдрөөс эхлэн ашиглалтад хүлээлгэн өгөх хүртэл тэмдэглэлийг хөтөлнө” гэсэн заасан байдаг.

Аудитын явцад ажилласан 6 сумдад хэрэгжсэн 7 төсөл, арга хэмжээнээс захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байдлыг барилга угсралтын дэвтрээс үзэхэд 4 төсөл, арга хэмжээнд дэвтэр нээсэн боловч 2 дэвтэрт 1 удаагийн хяналт хийсэн тухай

тэмдэглэл хөтөлсөн, 2 дэвтэрт хяналт хийсэн тухай тэмдэглэл хөтлөөгүй, 3 төсөл, арга хэмжээнд нээгээгүй байна.

Хүснэгт № 4 *Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл хөтөлсөн эсэх.*

№	Төсөл, арга хэмжээний нэр	Улаан дэвтэр нээсэн эсэх	Хяналт хийж, тэмдэглэл хөтөлсөн эсэх
1	Хутаг-өндөр Соёлын төв	Тийм	Хяналт хийсэн тэмдэглэл хөтлөөгүй.
3	Сэлэнгийн сургууль	Тийм	Хяналт хийсэн тэмдэглэл хөтлөөгүй.
2	Сайхан Соёлын төв	Тийм	ГХБХБГ нэг удаагийн хяналт хийсэн тухай тэмдэглэл хөтөлсөн.
4	Сургуулийн барилгын засвар (Бүрэгхангай сум)	Тийм	Аймгийн ГХБХБГ инженер 1 удаа хяналт хийсэн тэмдэглэл байна.
5	Сэлэнгийн Соёлын төв	Үгүй	
6	Хангалын сургууль	Үгүй	
7	18 дугаар байр хүртэлх чиглэлийн шугамын шинэчлэл (Булган сум)	Үгүй	

Барилга угсралтын ажил гүйцэтгэсэн тэмдэглэл хөтлөх журмын 5-д “Хяналтын болон захиалагч бусад холбогдох байгууллагуудаас барилгын ажилтай танилцаж үзсэн тохиолдолд ямар шаардлага, зөвлөмж өгсөн биелэлтийг шалгасан тухай тэмдэглэлд тодорхой тэмдэглэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Сумдад хэрэгжсэн төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт хийхдээ хяналт хийсэн анхан шатны баримтыг илтгэх хуудсаар танилцуулж хянуулан баримтжуулж байгаа боловч сумдад хэрэгжсэн ажлын 6 ажлын илтгэх хуудас дутуу байгаа нь хяналтыг бүрэн хийсэн эсэх нь тодорхойгүй байна. Аймгийн төвд хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрт хийсэн хяналтыг “Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл”-ийг хөтөлдөг байна.

Хүснэгт № 5. *Захиалагчийн хяналт хэрэгжүүлээгүй төсөл, арга хэмжээ.*

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
1	Сургуулийн спорт заалны дээврийн засварын ажил (Баяннуур сум)	2022	2023	80.0	80.0
2	Сургуулийн барилгын засвар (Сэлэнгэ сум)	2022	2023	496.0	246.0
3	Соёлын төвийн засвар (Сэлэнгэ сум)	2022	2023	350.0	200.0
4	Цэцэрлэгийн барилгын засвар (Дашинчилэн сум)	2023	2023	300.0	300.0
5	Сургуулийн барилгын засвар (Бүрэгхангай сум)	2023	2023	555.0	550.0
6	Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн засвар	2023	2023	172.5	172.5

Аудитын явцад Сайхан, Хутаг-Өндөр, Бугат, Хангал, Сэлэнгэ сум, Хялганат тосгонд хийсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг үзэхэд зураг төсвийн дагуу хийгээгүй, төсөвт тусгасан ажлуудаас дутуу хийсэн, засварын ажлууд чанаргүй болсон зэрэг зөрчлүүд байна. Тухайлбал:

1. Сайхан сумын соёлын төвийн их засварын ажлаас хяналтын камер хийх 4.3 сая төгрөгөөр цахилгааны гол шугам солих, разетка, унтраалга, автоматын хайрцаг иж бүрнээр сольсон.

2. Хутаг-Өндөр сумын соёлын төвийн их засварын ажлаас тайзны шалны 1.8 сая төгрөгөөр 1.6 сая төгрөгийн 2 хаалгыг 5.0 сая төгрөгийн хаалга суулгасан.

3. Сэлэнгэ сумын соёлын төвийн барилгын засварын ажлаас дотор заслын ажилд 340м2 тааз, 165ш нүдэн гэрэл суулгах ажил нь барилгын үндсэн тааз эвдрэлтэй гэсэн шалтгаанаар хийгдэхээр байсан ажил нь зураг төсвийн дагуу хийгдээгүй эвдрэлтэй байгаа хэсгийг нөхөн сэргээж, хуучин дүүжин таазыг хэсэгчлэн сольсон бөгөөд үүнээс 148 м2 дүүжин таазыг шинээр, 52м2 талбайд заслын ажил хийгдсэн.

4. Сэлэнгэ сумын сургуулийн хичээлийн байрны барилгын их засвар: Засвар хийсэн гал тогооны өрөөний хана, таазны будаг хуурсан, дээврийн карниз шинээр хийгээгүй, салхивчийн систем ажиллаагүй байна.

5. Хангал сумын сургуулийн хичээлийн байрны их засварын ажлаас улсын комиссын хурлын тэмдэглэлд цонхны амлагааг гүйцээж хийх үүрэг даалгавар өгсөн биелэлтийг тооцоогүй дахин хяналт хэрэгжүүлээгүй байна.



“Сэлэнгэ сумын сургуулийн гал тогооны засвар хийсэн хэсгийн будаг замаск хуурсан байдал”



“Сэлэнгэ сумын сургуулийн дээврийн карниз, усны хаялаг хийгдээгүй”



“Хангал сумын сургуулийн засварын дутуу хийсэн цонхны амлагаа”

Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Барилгын ажлын захиалагчийн дүрэм"-ийн 3.11-д "Захиалагч барилга байгууламжийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагаас хийх үзлэг, шалгалтын ажилд оролцож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах ажлыг зохион байгуулах үүрэгтэй." 3.16-д "Барилгын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгээгүй, чанаргүй, дутуу гүйцэтгэсэн, захиалагч болон эрх бүхий байгууллагын шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд захиалагч барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийг баталгаажуулахгүй, энэ тохиолдолд төсвийн ерөнхийлөн захирагч болон хөрөнгө оруулагч санхүүжилт олгохгүй байж болно." гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, төсөл арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт үр дүнгүй байна.

Б.2.2 Хэрэгжиж дууссан төсөл арга хэмжээнээс 952.6 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагууд бүртгэлд тусгаагүй байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 72 төсөл арга хэмжээнд 11,445.4 сая төгрөгийг баталж, хэрэгжүүлснээс 13 төсөл арга хэмжээний 1,005.5 сая төгрөгийн ажил нь урсгал зардлын шинжтэй бүртгэлд тусгах шаардлагагүй хөрөнгө оруулалтууд

байгаа бол данс бүртгэлд тусгах 8,406.6 сая төгрөгийн төсөв өртөгтэй 55 төсөл, арга хэмжээ байгаагаас 39 төсөл, арга хэмжээний 5016.6 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагууд аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/10 тоот захирамжийн дагуу бүртгэлд тусгажээ.

Харин Булган сумын 4 дүгээр багийн гудамж, талбай гэрэлтүүлгийн ажлыг 114.5 сая төгрөгөөр гүйцэтгэсэн ч данс бүртгэлд тусгахдаа 11.4 сая төгрөгөөр бүртгэж 103.1 сая төгрөгийн зөрүүтэй тусгасан, 952.6 сая төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг данс бүртгэлд тусгаагүй байна.

Хүснэгт № 6 Данс бүртгэлд тусгаагүй хөрөнгийг хүснэгтээр харуулбал

/сая.төг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Бүртгэлд тусгаагүй дүн	Бүртгэлд тусгах шийдвэр	Тайлбар
1	Нийтийн биеийн тамирын талбай байгуулах (Булган сум)	500.0	485.6	Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн А/10 тоот захирамж	Данс бүртгэлд тусгаагүй
2	Тоглоомын талбай байгуулах (Булган сум 2 дугаар баг)	56.0	56.0		Данс бүртгэлд тусгаагүй
3	Аймгийн төвийн хяналтын камерыг өргөтгөх, шинэчлэх	100.0	99.8		Данс бүртгэлд тусгаагүй
4	Төрийн албаны цахим шилжилт-Ухаалаг Булган цахим системийг нэвтрүүлэх	138.4	135.0		Захирамж гараагүй программ Данс бүртгэлд тусгаагүй
5	Зарим багийн дарга нарт мотоцикл олгох (8)	26.7	16.4		Орхон сумын ЗДТГ 1, Хутаг-Өндөр сумын ЗДТГ 2 мотоцикл хүлээж аваагүй, Сэлэнгэ сумын ЗДТГ 1, ОБГ-н 50-р анги 1 мотоцикл бүртгэлд тусгаагүй.
6	Сумын ЭМТ-ийн эмч, багийн эмч нарыг зөөврийн компьютероор хангах (5 ш)	15.0	11.2		Гурванбулаг сумын ЭМТ-ийн бүртгэлд байхгүй хүлээж аваагүй, бусад 3 зөөврийн компьютерыг сумын ЭМТ-д олгоогүй.
7	Тусгай тоноглолтой автомашин (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар)	150.0	148.5		Данс бүртгэлд тусгаагүй
	Нийт	986.1	952.6		

Үүнээс “Зарим багийн дарга нарт мотоцикл олгох” 26.7 сая төгрөгийн 8 мотоциклоос Орхон сумын ЗДТГ-т 1, Хутаг-Өндөр сумын ЗДТГ-т 2 нийт 9.9 сая

төгрөгийн 3 мотоциклын хүлээлгэн өгсөн гэх боловч ашиглагч байгууллагад олгоогүй байна.

“Төрийн албаны цахим шилжилт-Ухаалаг Булган цахим системийг нэвтрүүлэх” 135.0 сая төгрөгийн ажил хийгдэж дууссан бүртгэлд тусгах шийдвэр гараагүй байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар хийсэн их засвар ажлын бүртгэл

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийх 25 засварын ажил батлагдаж Нэгдсэн эмнэлгийн Халдвартын тасгийн барилгын засварын ажил хийгдээгүй байна.

Их засвар хийгдэж дууссан 24 ажлаас барилгын өртгийг нэмэгдүүлж капиталжуулах 16 ажил байгаагаас 1,286.6 сая төгрөгийн 5 ажлыг данс бүртгэлд тусгаагүй байна.

Хүснэгт № Их засварын ажлаас данс бүртгэлд тусгаагүй хөрөнгийг хүснэгтээр харуулбал

/сая төгрөгөөр/

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Бүртгэлд тусгаагүй дүн	Бүртгэлд тусгах шийдвэр	Тайлбар
1	Сургуулийн спорт заалны дээврийн засварын ажил (Баяннуур сум)	80.0	75.9	Захирамж гараагүй	капиталжаагүй
2	Сургуулийн барилгын засвар (Сэлэнгэ сум)	496.0	496.0	Захирамж гараагүй	капиталжаагүй
3	Сургуулийн барилгын засвар (Бүрэгхангай сум)	550.0	535.4	Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ны өдрийн А/10 тоот захирамж	Капиталжуулаагүй
4	Төсвийн байгууллагуудын сантехникийн засвар (Баяннуур сум)	80.0	79.6		Капиталжуулаагүй
5	Соёлын төвийн барилгын засвар (Сайхан сум)	100.0	99.9		Капиталжуулаагүй
	Нийт	1,306.0	1,286.8		

Дээрх 5 ажлаас 3 төсөл арга хэмжээг данс бүртгэлд тусгах шийдвэр гарсан ч холбогдох байгууллагууд бүртгэлд тусгаагүй байна.

Харин “Баяннуур сумын сургуулийн спорт заалны дээврийн засвар” 75.9 сая, Сэлэнгэ сумын Сургуулийн барилгын засвар 496.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгах шийдвэр гараагүй байна.

Мөн их засвар хийгдэж дууссан ажлуудаас “Сэлэнгэ сумын Соёлын төвийн засвар” 193.5 сая, “Аймгийн Ахмадын амралтын барилгын засвар” 243.9 сая, “Хангал сумын Сургуулийн барилгын засвар”-ын 189.2 сая төгрөгийн 3 ажлыг барилгын

өртгийг нэмж капиталжуулаагүй засварын ажлыг тусад нь орлого авч буруу бүртгэсэн зөрчил илэрсэн.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгсэн ажлуудыг бүртгэлд тусгаагүй нь Булган аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2014 оны 17 дугаар тогтоолын хавсралтын 3.6-д “Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт гадаад дотоодын төсөл хөтөлбөр, хандив тусламжийн хүрээнд шинээр бий болсон, төрийн өмчөөс үнэ төлбөргүй шилжүүлсэн ашиглагч байгууллага нь тодорхойгүй байгаа үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг Өмчийн алба хүлээн авч бүртгээд, эрх бүхий байгууллагатай зөвшилцөн эзэмшигч, ашиглагч байгууллагыг тогтоож, хөрөнгийг хүлээлгэн өгнө.”, 3.7-д “Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж буй дуусаагүй барилга байгууламжийг дараах байдлаар бүртгэнэ.”, 3.7.1 “Зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэлээр акт үйлдэн тухайн жилийн 12 дугаар сарын 20-ны дотор Өмчийн албанд хүргүүлнэ.”, 3.7.2 “Өмчийн албан уг гүйцэтгэлийн актыг үндэслэн орон нутгийн өмчийн “Дуусаагүй барилга байгууламжийн бүртгэл”-д бүртгэж, орон нутгийн төсвийн нэгдсэн санхүүгийн тайланд үлдэгдлээр үлдээнэ” гэсэн заалтууд бүрэн хэрэгжихгүй байна.

Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлсэн байна.
- Хөрөнгө оруулалтын жагсаалтад батлагдсан нийт төсөл арга хэмжээний 54.2 хувь нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдаагүй байна.
- Захиалагчийн хяналтыг хангалтгүй хийснээс зарим хөрөнгө оруулалтын гүйцэтгэл зураг төсвийн дагуу хийгээгүй, төсөвт тусгасан ажлуудаас дутуу хийсэн, засварын ажлууд чанаргүй болсон байна.
- Худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан байна.
- Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ: Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Баттулгад:

- Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, ашиглалтад тавих хяналтыг сайжруулж, ИТХ-аас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж ажиллах.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Ү.Бямбасүрэнд:

- Барилга байгууламж, өргөтгөл, шинэчлэлтийн ажил бүрд “Барилга угсралтын ажил гүйцэтгэсэн тэмдэглэл”-ийн дэвтэр нээлгэж, хяналт хийсэн тухай тэмдэглэлийг хөтөлж хэвшүүлэх.
- Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ баталсан зураг төсөвт тусгасан ажил бүрээр хяналт хийж, анхан шатны баримтаар баталгаажуулан ажлын гүйцэтгэлийг бодитой гаргаж баталгаажуулж, хяналт хэрэгжүүлж байгаа албан хаагчдын ажлын хариуцлагыг сайжруулах.